

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/134/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Магсаржалам  
Утас: 88114867 Цахим хаяг: [khaan.soyombo.audit@gmail.com](mailto:khaan.soyombo.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
3.5.3 Нэмэлт төсөв.....	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

№ 01/184  
-ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэнтогтох сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрэнтогтох сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлж байна. Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 58,367.0 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 8,169.0 мянган төгрөгийн эмийн шууд худалдан авалт хийсэн, хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү хэмжээгээр худалдан авалт хийсэн, нийгмийн эрүүл мэндийн зардлыг бараа материалын дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэж тайлагнасан зэрэг алдаа, зөрчил илэрсэн

### Бусад асуудлын хэсэг

Бүрэнтогтох сумын ЭМТ нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 3 зорилт 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 90.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	218,276,589.43	217,602,658.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	58,367,009.54
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	58,367,009.54
3121	Төгрөг	00.00	58,367,009.54
31211	Төрийн сангийн харилцах	00.00	58,367,009.54
33	АВЛАГА	78,692,300.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	78,692,300.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	139,584,289.43	159,235,648.95
351	Түүхий эд материал	50,105,844.38	40,998,655.04
35130	Эм боох материал	50,105,844.38	40,998,655.04
354	Хангамжийн материал	87,697,020.05	116,437,568.91
35410	Бичиг хэргийн материал	3,602,775.00	3,134,750.00
35420	Аж ахуйн материал	40,166,414.84	61,964,817.62
35450	Барилгын засварын материал	5,735,407.00	6,926,355.00
35460	Хүнсний материал	4,838,661.92	10,762,852.80
35470	Бусад хангамжийн материал	33,353,761.29	33,648,793.49
35600	Мал амьтад	1,781,425.00	1,799,425.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,590,153,880.31	1,558,785,446.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,590,153,880.31	1,558,785,446.60
392	Биет хөрөнгө	1,570,153,880.31	1,522,895,446.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,679,488,825.00	1,677,749,985.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-261,069,938.04	-324,873,087.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,666,896.55	87,250,896.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	-37,379,320.15	-51,047,247.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	108,703,824.52	136,969,426.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,002,635.07	-37,097,548.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,868,575.56	40,248,429.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,802,101.06	-13,192,342.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,753,867.00	14,753,867.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,074,114.00	-7,866,932.88
393	Биет бус хөрөнгө	20,000,000.00	35,890,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,000,000.00	35,890,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,808,430,469.74	1,776,388,105.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,808,430,469.74	1,776,388,105.09
51	Засгийн газрын хувь оролцоо	1,808,430,469.74	1,776,388,105.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	212,702,788.00	212,702,788.00
51101	Өмч: - төрийн	212,702,788.00	212,702,788.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,475,869,165.48	1,444,947,067.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,475,869,165.48	1,476,989,431.65
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-32,042,364.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	119,858,516.26	118,738,250.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,808,430,469.74	1,776,388,105.09

2.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,015,128,646.92</b>	<b>749,328,426.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>335,552,786.92</b>	<b>98,614,306.26</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	335,552,786.92	98,614,306.26
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	409,913,200.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	185,977,500.00	1,146,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	487,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,312,500.00	659,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	42,110,100.00	46,104,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,110,100.00	46,104,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	41,575,060.00	603,463,520.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	41,575,060.00	603,463,520.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>877,607,078.18</b>	<b>781,370,790.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>877,607,078.18</b>	<b>781,370,790.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	844,027,078.18	781,370,732.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	348,935,049.00	405,218,265.39
210101	Үндсэн цалин	196,813,056.00	217,909,121.93
210102	Нэмэгдэл	115,399,522.00	137,832,059.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,189,160.00	5,016,000.00
210104	Урамшуулал	20,194,417.00	35,810,884.46
210105	Гэрээт ажлын хөлс	7,338,894.00	8,650,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	49,001,273.00	49,696,742.07
210201	Тэтгэврийн даатгал	35,816,741.92	34,722,242.07
210202	Тэтгэмжийн даатгал	3,335,667.37	3,743,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,628,213.81	2,995,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	650,115.16	748,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,570,534.74	7,487,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,110,100.00	42,110,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,895,490.00	2,461,447.00
210302	Түлш, халаалт	37,214,610.00	39,648,553.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,177,232.80	54,485,746.09
210401	Бичиг хэрэг	1,229,340.00	4,663,250.00
210402	Тээвэр, шатахуун	16,819,625.00	20,991,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,090,000.00	2,610,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,119,243.00	3,780,647.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,919,024.80	6,144,619.72
210408	Бараа материал акталсны зардал	00.00	16,295,688.67
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	263,885,760.92	97,226,177.65
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	248,480,799.28	87,191,568.53
210502	Хоол, хүнс	15,404,961.64	10,034,609.12
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,431,960.00	9,414,745.00
210604	Урсгал засвар	3,431,960.00	9,414,745.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	908,000.00	1,482,000.00
210702	Дотоод албан томилолт	908,000.00	1,482,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,815,067.00	4,796,116.00

Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	279,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,200.00	154,311.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	150,500.00	183,852.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	912,417.00	1,483,453.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>97,762,635.46</b>	<b>116,940,940.71</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,062,810.00	14,856,541.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	92,699,825.46	102,084,399.71
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,580,000.00</b>	<b>58.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,580,000.00</b>	<b>00.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	33,400,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,000.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>137,521,568.74</b>	<b>-32,042,364.65</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>15,000,000.00</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,000,000.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-15,000,000.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>122,521,568.74</b>	<b>-32,042,364.65</b>

СТ-3А

**2.3 Мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>600,883,560.00</b>	<b>729,406,420.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>		<b>78,692,300.00</b>
<b>1200042</b>	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		78,692,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>600,883,560.00</b>	<b>650,714,120.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	409,913,200.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>107,285,200.00</b>	<b>1,146,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,312,500.00	659,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>42,110,100.00</b>	<b>46,104,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,110,100.00	46,104,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>41,575,060.00</b>	<b>603,463,520.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	41,575,060.00	603,463,520.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>597,903,560.00</b>	<b>651,364,410.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>597,903,560.00</b>	<b>651,364,410.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>564,323,560.00</b>	<b>651,364,352.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>350,502,722.00</b>	<b>403,332,507.46</b>
210101	Үндсэн цалин	196,813,056.00	216,023,364.00
210102	Нэмэгдэл	115,399,522.00	137,832,059.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,189,160.00	5,016,000.00
210104	Урамшуулал	21,116,084.00	35,810,884.46
210105	Гэрээт ажлын хөлс	7,984,900.00	8,650,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>47,066,259.00</b>	<b>51,582,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	33,851,139.00	36,608,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,303,730.00	3,743,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,642,964.00	2,995,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	660,866.00	748,700.00

Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	6,607,560.00	7,487,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,110,100.00</b>	<b>42,110,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,895,490.00	2,461,447.00
210302	Түлш, халаалт	37,214,610.00	39,648,553.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>32,496,682.00</b>	<b>48,361,140.00</b>
210401	Бичиг хэрэг	3,130,700.00	4,255,400.00
210402	Тээвэр, шатахуун	16,819,625.00	20,991,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,090,000.00	2,830,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,184,800.00	8,556,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,271,557.00	11,728,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>80,595,337.00</b>	<b>62,074,001.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,478,258.00	42,419,201.00
210502	Хоол, хүнс	11,617,079.00	16,154,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000.00	3,500,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,923,000.00</b>	<b>22,828,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,923,000.00	1,725,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	10,103,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	11,000,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>908,000.00</b>	<b>1,482,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	908,000.00	1,482,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,902,650.00</b>	<b>4,905,563.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	279,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,200.00	154,311.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	150,500.00	183,852.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	1,592,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,818,810.00</b>	<b>14,688,541.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,818,810.00	14,688,541.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,580,000.00</b>	<b>58.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,580,000.00</b>	<b>00.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	33,400,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,000.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>2,980,000.00</u></b>	<b><u>78,042,009.54</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,980,000.00</b>	<b>19,675,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,980,000.00</b>	<b>19,675,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,980,000.00</b>	<b>19,675,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,980,000.00	19,675,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-2,980,000.00</u></b>	<b><u>-19,675,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>58,367,009.54</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>58,367,009.54</b>

## 2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	212,702,788.00	120,928,086.78	1,352,278,026.22	1,685,908,901.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,069,570.52	1,069,570.52
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>212,702,788.00</b>	<b>120,928,086.78</b>	<b>1,353,347,596.74</b>	1,686,978,471.52
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	122,521,568.74	122,521,568.74
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>212,702,788.00</b>	<b>119,858,516.26</b>	<b>1,475,869,165.48</b>	1,808,430,469.74
D01	<b>2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>212,702,788.00</b>	<b>119,858,516.26</b>	<b>1,475,869,165.48</b>	1,808,430,469.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,120,266.17	1,120,266.17
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>212,702,788.00</b>	<b>119,858,516.26</b>	<b>1,476,989,431.65</b>	1,809,550,735.91
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,120,266.17	00.00	-1,120,266.17
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-32,042,364.65	-32,042,364.65
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>212,702,788.00</b>	<b>118,738,250.09</b>	<b>1,444,947,067.00</b>	1,776,388,105.09

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	693,474,300.00	671,039,352.46	22,434,947.54	96.8
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	693,474,300.00	671,039,352.46	22,434,947.54	96.8
210	Бараа, үйлчилгээний зардал	693,474,300.00	671,039,352.46	22,434,947.54	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	411,296,900.00	403,332,507.46	7,964,392.54	98.1
210101	Үндсэн цалин	221,792,600.00	216,023,364.00	5,769,236.00	97.4
210102	Нэмэгдэл	139,838,200.00	137,832,059.00	2,006,141.00	98.6
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	5,016,000.00	5,016,000.00	-	100.0
210104	Урамшуулал	35,999,900.00	35,810,884.46	189,015.54	99.5
210105	Гэрээт ажлын хөлс	8,650,200.00	8,650,200.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,582,500.00	51,582,500.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	36,608,000.00	36,608,000.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,743,700.00	3,743,700.00	-	100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	2,995,000.00	2,995,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	748,700.00	748,700.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,487,100.00	7,487,100.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,110,000.00	42,110,000.00	-	100.0
210301	Гэрэл цахилгаан	3,022,400.00	2,461,447.00	560,953.00	81.4

**Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	38,687,600.00	39,648,553.00	(960,953.00)	102.5
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	-	400,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	53,522,000.00	48,361,140.00	5,160,860.00	90.4
210401	Бичиг хэрэг	5,138,500.00	4,255,400.00	883,100.00	82.8
210402	Тээвэр (шатахуун)	23,070,400.00	20,991,540.00	2,078,860.00	91.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	5,028,900.00	2,830,000.00	2,198,900.00	56.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,556,000.00	8,556,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	11,728,200.00	11,728,200.00	-	100.0
2105	Нормативт зардал	62,366,000.00	62,074,001.00	291,999.00	99.5
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	42,419,200.00	42,419,201.00	(1.00)	100.0
210502	Хоол, хүнс	16,154,700.00	16,154,700.00	-	100.0
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	3,792,100.00	3,500,100.00	292,000.00	92.3
2106	Эд хогшил худалдан авах	42,503,100.00	42,503,100.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,400,000.00	21,400,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	10,103,000.00	10,103,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	11,000,100.00	11,000,100.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,521,000.00	1,482,000.00	2,039,000.00	42.1
210702	Дотоод албан томилолт	3,521,000.00	1,482,000.00	2,039,000.00	42.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,981,900.00	4,905,563.00	1,076,337.00	82.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,440,000.00	1,440,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	279,500.00	279,500.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	154,400.00	154,311.00	89.00	99.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	183,900.00	183,852.00	48.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,669,100.00	1,592,900.00	1,076,200.00	59.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,590,900.00	14,688,541.00	5,902,359.00	71.3
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>693,474,300.00</b>	<b>728,747,420.00</b>	<b>(35,273,120.00)</b>	<b>105.1</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>46,104,600.00</b>	<b>46,104,600.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	46,104,600.00	46,104,600.00	-	100.0
1340	<b>НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>647,369,700.00</b>	<b>682,155,820.00</b>	<b>(34,786,120.00)</b>	<b>105.4</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	647,369,700.00	682,155,820.00	(34,786,120.00)	105.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,146,000.00	(1,146,000.00)	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	487,000.00	(487,000.00)	-
131104	Дээд шатны төсөв захирагчаас ирүүлсэн төсөв	-	659,000.00	(659,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	58,367,009.54	(58,367,009.54)	-
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	24.00	24.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ЭМТ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал хүртээмж чанар, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээний стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чандлан сахидаг чадварлаг эмч, мэргэжилтэн бүхий төрийн үйлчилгээг төлөвшүүлэхээр зорилт тавин ажиллаж байна. Үүнд:

1. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулна.
2. Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээг хөгжүүлж, эмчилгээ үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
3. Хувь хүн, гэр бүл, төрийн ба төрийн бус байгууллагуудын оролцоотой хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, орчныг бүрдүүлэх
4. Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чанартай, хүртээмжтэй тусламж үйлчилгээг үзүүлж, өөрийн байгууллагын тусламж үйлчилгээний чанарын шалгуурыг хангаж ажиллана.
5. Эрүүл ахуйн нөхцөл Халдвараас сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж стандартын шаардлагыг хангаж ажиллах

Бүрэнтогтох сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэгт хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан<sup>1</sup> 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан<sup>2</sup> тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох

<sup>1</sup> "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай"

<sup>2</sup> "Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай"

нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:**

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 02 сарын 20-ны өдрийн А/02 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд 4 заалт бүхий 15 хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ. Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар 2019 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32,042.4 мянган төгрөгөөр буюу 18.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	58,367.0	-58,367.0
Авлага	78,692.0	0	-78,692.0
Бараа материал	139,584.3	159,235.6	-19,651.3
Үндсэн хөрөнгө	1,933,031.9	1,993,412.6	-60,380.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,808,430.5</b>	<b>1,776,388.1</b>	<b>32,042.4</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,808,430.5	1,776,388.1	32,042.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,808,430.5</b>	<b>1,776,388.1</b>	<b>32,042.4</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө данс өмнөх оноос нэмэгдэж, авлага данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 58,367.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгалын сангаас хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 19,651.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь корона вирусын үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлттэй холбоотой үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 60,380.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 70,715.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 19,675.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 51,040.9 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө авсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 479,312.2 мянган, орон нутгийн төсвөөс 57,779.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэх дүн 479,312.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 57,779.3 мянган төгрөгөөр оны эхэнд баталсан байна. Тайлант оны хагас жилээр орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийн дүнг бууруулж баталсан нь байгууллагын төрийн үйлчилгээний ажилчдад

олгох цалинг хассантай холбоотой, улсын төсвөөс авах санхүүжилтийн дүнг нэмэгдэж батлагдаж ирсэн нь тухайн эрүүл мэндийн байгууллагын 1-6 сарын гүйцэтгэлтэй холбоотойгоор төсөвт өөрчлөлт орсон байна.

Тус байгууллагын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг Эрүүл мэндийн яамнаас 1 дүгээр сард баталж ирүүлсэн ба эхний хагас жилийн гүйцэтгэлд үндэслэн 6 сард Эрүүл мэндийн яамнаас төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Тус өөрчлөлтөөр анх баталсан төсвийг 72,509.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Эрүүл мэндийн байгууллагын төсвийн төлөвлөлт нь сүүлийн 3 жилийн гүйцэтгэлээр хийгддэг тул төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй хийгдэж байна гэж үзсэн.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан орон нутгийн төсвөөс баталсан төсвийг 11,674.1 мянган төгрөгөөр бууруулж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих дүнг 168,057.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 647,369.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 46,104.6 мянган орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 603,463.5 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн дагуу зарцуулж, 58,367.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 46,104.6 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 58 төгрөг байна.

Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл 624,934.8 мянган төгрөг буюу 96.5 хувьтай, орон нутгийн төсвийн гүйцэтгэл 46,104.5 мянган төгрөг 100 хувьтай нийт зарлагын гүйцэтгэл 672,185.3 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь улсын төсвийн зардлаас бараа үйлчилгээний зардлын төсвийг 58,367.0 мянган төгрөг дутуу зарцуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	348,263.1	330,821.9	17,441.1	95%
2	Үндсэн тусламж үйлчилгээ	203,558.3	198,564.5	4,993.7	94.5%
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан	1,146.0	1,146.0	0	100%
4	Дээд шат нэмэлт төсөв	95,548.3	95,548.3	0	100
5	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	44,110.0	44,110.0	0	100%
6	Нийтлэг үйлчилгээ	1,994.6	1,994.6	0	100%
	Дүн	694,620.3	672,185.3	22,434.8	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. 2022 онд улсын төсвийн байгууллага болсноор төрийн санд байршдаг 100170420401 тоот нэмэлт төсвийн дансыг улсын төсвийн харилцах данс руу нийлүүлж тайлагнасан болно.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, Аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 877,607.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 17,552.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 12,286.5 мянган төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам<sup>3</sup>-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 32,782.1 мянган төгрөгийн 2 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй тул шилэн дансанд зөвлөмж хүргүүлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага байхгүй, Шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгсөн хэрэгжилтийг ханган биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0	1	0	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 8,169.0 мянган төгрөгийн тендергүй эмийн худалдан авалт хийсэн байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 133,675.7 мянган төгрөгийн алдаа<sup>3</sup> илэрснээс аудитын явцад 85,900.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 47,774.9 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 78,692.3 мянган төгрөг авсан ба үүнийг 2022 оны мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу сонгож тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 7,208.5 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэснийг залруулсан болно.

<sup>3</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 47,774.9 мянган төгрөгийн зөрчил<sup>4</sup> илэрснээс 47,774.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй байна.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Бараа материалтай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Бараа материалын тайланг анхан баримттай тулган шалгахад нийгмийн эрүүл мэндийн зардал болох 4,388.5 мянган төгрөгийн материалыг бараа материалын дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.21 дэх заалтыг зөрчсөн байна.

##### Өгсөн зөвлөмж:

Нийгмийн эрүүл мэндийн зардлыг бараа материалын дансаар дамжуулж тайлагнаж байх .

#### 2. Бараа материалтай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү хэмжээгээр 4,130.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; гэсэн заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлж, үр ашиггүй зардал гаргахгүй байх

#### 3. Зардалтай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Ковид 19-ын эсрэг вакцин 4,495.6 мянган төгрөгийн үнэ бүхий 550 ширхэг вакцины хугацаа дууссан гэж данснаас хассан ба уг вакциныг устгаагүй ямар нэгэн анхан шатны баримтгүй шууд данснаас хасаж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалттай нийцээгүй ба "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж тайлагнахгүй байх

#### 4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е-баримт/ баримтгүй 1,977.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

<sup>4</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримт бүрдүүлж ажиллах.

## 5. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 32,782.1 мянган төгрөгийн 2 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан	1	78,692.3			1	78,692.3	1	78,692.3				
эдийн засгийн ангилал буруу сонгосон	1	7,208.5			1	7,208.5	1	7,208.5				
Дүн	2	85,900.8			2	85,900.8	2	85,900.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэсэн	1	4,388.5					1	4,388.5				
Сарын бодит хэрэглээнээс илүү материал нөөцөлсөн	1	4,130.8					1	4,130.8				
Анхан шатны баримт бүрдэл	1	4,495.6					1	4,495.6				
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	1,977.9					1	1,977.9				
Дүн	4	14,992.8					4	14,992.8				

Аудитаар нийт 47,774.9 мянган төгрөгийн зөрчил<sup>4</sup> илэрснээс 47,774.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй байна.

### **5.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөөгүй болно.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Бараа материалтай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Бараа материалын тайланг анхан баримттай тулган шалгахад нийгмийн эрүүл мэндийн зардал болох 4,388.5 мянган төгрөгийн материалыг бараа материалын дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.21 дэх заалтыг зөрчсөн байна.

##### Өгсөн зөвлөмж:

Нийгмийн эрүүл мэндийн зардлыг бараа материалын дансаар дамжуулж тайлагнаж байх .

#### **2. Бараа материалтай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү хэмжээгээр 4,130.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; гэсэн заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлж, үр ашиггүй зардал гаргахгүй байх

#### **3. Зардалтай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Ковид 19-ын эсрэг вакцин 4,495.6 мянган төгрөгийн үнэ бүхий 550 ширхэг вакцины хугацаа дууссан гэж данснаас хассан ба уг вакциныг устгаагүй ямар нэгэн анхан шатны баримтгүй шууд данснаас хасаж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалттай нийцээгүй ба "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж тайлагнахгүй байх

#### **4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е–баримт/ баримтгүй 1,977.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

---

<sup>4</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримт бүрдүүлж ажиллах.

### 5. Шилэн данстай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 32,782.1 мянган төгрөгийн 2 гүйлгээ мэдээлээгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан	1	78,692.3			1	78,692.3	1	78,692.3				
эдийн засгийн ангилал буруу сонгосон	1	7,208.5			1	7,208.5	1	7,208.5				
Дүн	2	85,900.8			2	85,900.8	2	85,900.8				

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэсэн	1	4,388.5					1	4,388.5				
Сарын бодит хэрэглээнээс илүү материал нөөцөлсөн	1	4,130.8					1	4,130.8				
Анхан шатны баримт бүрдэл	1	4,495.6					1	4,495.6				
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	1,977.9					1	1,977.9				
Дүн	4	14,992.8					4	14,992.8				

**Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй байна.	1	32,782.1					1	32,782.1
Дүн	1	32,782.1					1	32,782.1

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

Х.ДИЙМАА ОГНОО:

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО:

